



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/178

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ОХУ-ын Өвөр-Байгалийн Хязгаар мужийн амбан захирагч Н.Н.Ждановагийн урилгаар 2017 оны 5 дугаар сарын 09-ний өдөр Өвөр-Байгалийн Хязгаар мужийн Чита хотод болох ялалтын баярт аймгийн Засаг дарга Н.Ганбямбаар ахлуулсан төлөөлөгчдийг оролцоход 1894500 /нэг сая найман зуун ерэн дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



01 920

Аймгийн Засаг даргын 2017 оны  
05 дугаар сарын 04 өдрийн 1178  
дугаар захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ТООЦОО

Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ /төгрөг/
Шатахуун /нийт 2200 км/	1800 төгрөг	440 л	792,000
Томилолтын зардал	35500*5хүн=177500	3 өдөр	532,500
Замын хүнс		150,000	
Хилээр орж гарах хураамж		50,000	
Бэлэг дурсгал	Зураг	120,000	
	Ууттай бэлэг /10/	250,000	
Нийт			1,894,500 төгрөг